“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

2020 оны 12 дугаар сарын 15 Багануур дүүрэг

| Д/д | Өргөдөл, гомдлын агуулга | Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо | Шийдвэрлэх шатандаа байгаа | | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | | | | | Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр | | | Өргөдлийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэх хугацаандаа байгаа | Хугацаа хэтэрсэн | 1-10 хоногт | 11-20 хоногт | 21-30 хоногт | Хугацаа сунгасан | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо | Албан бичгээр | Утсаар | Биечлэн уулзах | Талархал | Санал | Хүсэлт | Гомдол | Мэдээлэл |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 | Ажил хүссэн | 1 | | | 1 | | | | | | | + | | | + | | |
| 2 | Дэмжлэг туслалцаа хүссэн | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл | 1+2 | | | 1+2 | | | | | | + | + | | | + | | |
| 5 | Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Бусад | | | | | | | | | | | | | | | | |
| | Нийт | 4 | | | 4 | | | | | | | 4 | | | 4 | | |

## Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

| № | Ангилал | Тоо | Шалтгаан, тайлбар |
|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 |
| 1 | Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл | 4 | - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолооч ажилтай Намсрайн Жаргалсайханы ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул Н.Жаргалсайханыг Багануур үйлдвэрлэл, технологийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/01 дугаартай тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөв.<br><br>- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолоочоор ажиллаж байсан Дамбачимэдийн Бат-Эрдэнэ Хэнтий аймгаас нүүн ирж эргээд ажиллах боломжтой болсон тул ажилд орох хүсэлт гаргасан. Д.Бат-Эрдэнийг Багануур үйлдвэрлэл, технологийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/02 дугаартай тушаалаар Жолоочийн албан тушаалд томилов.<br><br>- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т Захиргааны албаны Ахлах мэргэжилтнээр ажилладаг Э.Энхзаяагийн цэцэрлэгийн хүүхдийн ангийн туслах багшид КОВИД-19 вирусын шинж тэмдэг илэрсэн тул тухайн хүний хавьтал болсон орчныг аюулгүй болох хүртэлх хугацаанд гэрээсээ цахимаар ажиллах хүсэлтийг зөвшөөрөв. Э.Энхзаяа 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл цахимаар ажиллав.<br><br>- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т Төсөл, хөрөнгө оруулалтын Эдийн засагчаар ажилладаг Б.Зоригт хадам ээжээрээ гэртээ хүүхдээ харуулж байсан боловч хадам ээжид нь КОВИД-19 вирусын шинжилгээний хариу эерэг гарч, Б.Зоригт нь гэртээ хүүхдээ харах, цахимаар ажиллах хүсэлт гарсан тул хүсэлтийн дагуу шийдвэрлэв. Цахимаар ажиллах хугацаанд Б.Зоригтод мөн халдварын шинж илэрч шинжилгээ хийлгэн хариу нь эерэг гарсан тул гэртээ тусгаарлагдаж, үргэлжлүүлэн цахимаар 021 оны 11 дүгээр сарын 11-нийг хүртэл ажиллав. |
| 2 | Боломжгүй тухай хариу өгсөн | - | - |
| 3 | Бусад | - | - |

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-Т ИРГЭД, АЛБАН ХААГЧДААС ГАРГАСАН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 15 Багануур дүүрэг

Манай байгууллагад 2021 онд жилийн эцсийн байдлаар иргэдээс ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, Коронавирусын улмаас гэрээсээ цахимаар ажиллахыг хүссэн утгатай нийт 4 өргөдөл ирсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал тооны хувьд цөөн байна. Тухайлбал, өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар манай байгууллагад 5 өргөдөл ирсэн байна. Үүнд: 2 иргэнээс ажилд орох хүсэлт, 2 ажилтан ажлаас чөлөөлөгдөх, 1 ажилтан тэтгэвэрт гарах болсны улмаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг тус бүр "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын даргын тушаалаар, өргөдөл гаргагчдын хүсэлтийн дагуу өдөр, өдөрт нь багтаан шийдвэрлэсэн.

Ирсэн 4 өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдлүүд болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн тус тус архивласан.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

Иргэдээс байгууллагын үйл ажилагаа, албан хаагчдын ёс зүйн харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөпөл байхгүй.

Бүтээлч санал санаачилгын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжийн дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачилгын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн нэг илрэл нь Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан гэрээ байгуулан ажиллаж байгаа явдал юм. Энэ ажлын хүрээнд Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВт-ын зураг төслийг ЭХЯ-наас олгосон техникийн нөхцөлийн дагуу боловсруулж Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан баталгаажуулсан. Эрчим хүчний яамны эрчим хүчний хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулан батлагдсан тус зураг төслийн төсвийг төсвийн экспертээр хянуулж эхний ээлжийн шүүмжийг авч засварлан баталгаажуулсан. Зураг төслийг эцсийн хувилбарыг 2021 оны 12 дугаар сарын 03-нд хүлээн авсан.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт 2018 оноос эхлэн улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

УЛААНБААТАР ХОТ БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ

ХЯНАСАН:
"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.МӨНХДУЛАМ